



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/588

Булган сум

“Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөр  
боловсруулах ажлын хэсэгт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.3, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, 18 дугаар зүйлийн 18.2, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоол “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай”, аймгийн ИТХ-ын 2024 оны IV дүгээр Хуралдааны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

М.Цэрэнчимэд (БОНХОБТХ-ийн Барилга, хот байгуулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн, аймгийн ерөнхий архитектор)

Ч.Оюун-Эрдэнэчимэг (БОНХОБТХ-ийн Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн)

С.Алтанзул (БОНХОБТХ-ийн Байгаль орчин, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Д.Алтаншагай (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)

М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010808

Б.Батбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Мэргэжлийн холбоод (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. "Үйлдвэрлэлийн сэргэлт" хөтөлбөр боловсруулахад эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангаж, улс, аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт боловсруулж, 3 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР